

## ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГЫН ДЭРГЭДЭХ ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛ БА ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДЛУУД

2022.02.27

Улаанбаатар хот

Монголын Өмгөөлөгчдийн Холбоо нь 2006 оноос 2012 он хүртэл Япон Улсын засгийн газрын гадаад харилцааны хамтын ажиллагааны байгууллага болох JICA-тай хамтран “Эвлэрлэн зуучлал”-ын чиглэлээр төсөл хэрэгжүүлж, мөн ондоо холбооныхоо дэргэд “Иргэний хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлах төв”-ийг 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллуулсан.

Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, JICA-тай хамтран хэрэгжүүлж байсан “Эвлэрлэн зуучлал” төслийн хүрээнд “Иргэний хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлах төв”-д ажиллаж буй өмгөөлөгч-эвлэрүүлэн зуучлагч нарыг “Эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх сургалт”, “Эвлэрүүлэн зуучлагч бэлтгэх багшийн сургалт”, “Эвлэрүүлэн зуучлалын тогтоог бий болгох” сургалтуудад үе шаттайгаар хамруулж бэлтгэсэн.

Ийнхүү эвлэрүүлэн зуучлалын чиглэлээр анхны мэргэжлийн хүмүүс, сургагч багш нар бэлтгэгдэж байсан түүхтэй.

Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дэргэдэх “Иргэний хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлах төв” нь 2006 оноос 2012 он хүртэл тасралтгүй үйл ажиллагаа явуулж, жилд дунджаар 20 гаран иргэний хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлах ажиллагааны үндсэн дээр шийдвэрлэж байсан нь тоон үзүүлэлтийн хувьд бага мэт харагдавч, ерөнхий үзүүлэлтээр нь JICA-ийн зүгээс хангалттай сайн гэж дүгнэж байсан болно.

Японы ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудтай харьцуулахад эдгээр тоон үзүүлэлт нь мөн л боломжийн дүн болох нь харагддаг.

2006 оноос 2012 он хүртэлх хугацаанд Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дэргэдэх “Иргэний хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлах төв”-ийн үйл ажиллагааг JICA олон улсын байгууллага нь тал бүрээр дэмжин ажиллаж байсны хувьд тус төв нь тогтвортой үйл ажиллагаа явуулж байсан. Мөн тухайн үеийн Монголын Өмгөөлөгчдийн Холбооны удирдлагууд дэмжиж, санаа тавин ажиллаж, үйл ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг шийдвэрлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан гэж хэлж болно.

Өөрөөр хэлбэл аливаа шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх ажиллагаа нь, түүний дотор “Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа” нь тухайн олон нийтийн байгууллагын удирдлагын болон санхүүгийн дэмжлэггүйгээр үндсэндээ явагдах боломжгүй байдаг болно.

Ийнхүү монголдоо анхдагч гэж хэлж болох шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх ажиллагааны нэг төрөл “Эвлэрүүлэн зуучлал”-ыг хэрэгжүүлж байсан Монголын Өмгөөлөгчдийн Холбооны дэргэдэх “Иргэний хэрэг маргааныг эвлэрүүлэн зуучлах төв”-ийн үйл ажиллагаа нь 2012 оны “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль” хэрэгжиж, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо татан буугдсан үйл явцтай зэрэгцэн үндсэндээ зогссон болно.

Хэдийгээр тус төвд мэргэжлийн эвлэрүүлэн зуучлагч нар ажиллаж байсан ч нийгэмд байх “хэрэг, маргааныг шүүхээр шийдвэрлэдэг” гэх давамгайл ойлголтын хүрээнд аажимдаа хэрэглэгч, үйлчлүүлэгчгүй болсон, мөн шинэ тулгар байгуулагдсан “Монголын Өмгөөлөгчдийн Холбоо” Төрийн бус Олон нийтийн байгууллага нь дүрмээрээ энэ чиглэлийн үйл ажиллагааг явуулах талаар тусгаж чадаагүй, мөн санхүүгийн хувьд ч дэмжиж ажиллаж чадахгүй болох ойлгомжтой байсан болно.

Өнөөдөр Монголын Худалдаа аж үйлдвэрийн танхим “Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх ажиллагаа”-ны чиглэлээр илтгэл сонсож, хэлэлцүүлэг өрнүүлж байгааг энэ чиглэлээр ажиллаж байсан хүний хувьд талархалтайгаар хүлээн авч байна.

Энэ бүхний эцэст миний хэлэх гээд байгаа гол санаа маань Нэгдүгээрт: аливаа эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь өөрөө уян хатан байхын зэрэгцээ, мөн тэр хэмжээгээрээ тухайн олон нийтийн байгууллагын дэмжлэгийг шаардаж байдаг, Хоёрдугаарт: хууль эрх зүйн орчны ялимгүй өөрчлөлт үйл ажиллагааны бүхэл бүтэн тогтолцоог үгүй хийж болдгийг л энд хэлэх гэсэн юм.

2012 оноос хойш Монголын Хуульчдийн Холбооны дэргэд “Эвлэрүүлэн зуучлалын хороо”, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дэргэдэх “Эвлэрүүлэн зуучлалын зөвлөл” энэ чиглэлийн үйл ажиллагааг өөр өөрийн чиглэлээр хариуцан явуулж байсан ч, эвлэрүүлэн зуучлалыг хөгжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чухам яг ямар үйл ажиллагаа явуулж байсан нь тодорхой бус л байна. Наад зах нь хуульчийн кредит цагийн үргэлжилсэн сургалтад “Эвлэрүүлэн зуучлалын хөтөлбөр” оруулчих талаар санал санаачлага гаргаагүй, бусдаад гаргасан энэ төрлийн санал, санаачлагыг дэмждэггүй, ажил хэрэг болгохгүй байгааг анхааруулах нь зүйтэй болов уу.

Цаашдаа шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх ажиллагааны нэг төрөл болох “Эвлэрүүлэн зуучлал”-ыг хөгжүүлэх, тухайн ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхийн тулд дараах ажил хэрэгч саналыг хэлэлцүүлэгт оруулж байна.

1. Шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр олон нийтэд хандсан мэдээ, мэдээлэл, сурталчилгааг идэвхижүүлэх, энэ чиглэлийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх арга замыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн хэмжээнд тавих...
2. Өмгөөлөгч, мөн бусад хуульчдад шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр байнгын кредит цагийн сургалтын хөтөлбөртэй болох, сургалт явуулдаг байх...
3. Хуульчид болон бусад чиглэлийн мэргэжлийн байгууллагуудын ажилтан нарыг эвлэрүүлэн зуучлалын чиглээр мэргэшүүлэх сургалтын хөтөлбөртэй болон, сургалт явуулдаг байх...
4. Олон нийтэд чиглэсэн мэдээлэл, сурталчилгааг явуулдаг байх ... гэх мэт.